

**НЭМЭЛТ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ
№ НАҮ-РХАА 2022-15**

2022-02-23

Улаанбаатар хот

Энэ гэрээг нэг талаас 2699877 регистрийн дугаартай “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК, /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ түүнийг төлөөлж, Зах зээл, санхүү хариуцсан дэд захирал Ц.Өнөрмаа,

нөгөө талаас 4065115 регистрийн дугаартай “Вестерн холд” ХХК /цаашид “Захиалагч” гэх/, түүнийг төлөөлж Цахилгааны инженер Д.Зоригт, /хамтад нь “Талууд” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн 2017 оны “Нэмэлт ажил үйлчилгээ явуулах журам”-ыг үндэслэн Талууд дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1.1. Гүйцэтгэгч нь “Вестерн холд” ХХК-иас Ховд аймгийн Буянт суманд хэрэгжиж буй “Ховд эко цемент”-ийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд баригдах 110 кВ-ын шугам, дэд станц, 10 кВ-ын гаргалгаа шугамуудыг ББЭХСистемтэй холбох үеийн реле хамгаалалтын тавилын тооцоог хийж гүйцэтгэх /цаашид “Гэрээт ажил” гэх/, Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэ гэрээний зорилго оршино.
- 1.2. Энэ гэрээнд тусгагдаагүй бусад харилцааг Монгол улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Энэ гэрээний Хавсралт-1-д “Вестерн холд” ХХК-иас Ховд аймгийн Буянт суманд хэрэгжиж буй “Ховд эко цемент”-ийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд баригдах 110 кВ-ын шугам, дэд станц, 10 кВ-ын гаргалгаа шугамуудыг ББЭХСистемтэй холбох үеийн реле хамгаалалтын тавилын тооцооны гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, үнэ тариф”-ыг хавсаргав. Хавсралт-1 нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.4. Энэ гэрээгээр гүйцэтгэсэн гэрээт ажил нь Талуудын оюуны өмч болох тул гуравдагч этгээдэд дамжуулах болон ашиглуулах тохиолдолд нөгөө Талын зөвшөөрлийг заавал авна.

ХОЁР. ГЭРЭЭТ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

- 2.1 Гүйцэтгэгч нь гэрээт ажлын төлбөрийг төлсөн өдрөөс эхлэн ажлын 21 /хорин нэг/ хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- 2.2 Захиалагчаас хамаарсан болон Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад тохиолдолд гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгэнэ.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР ТООЦОО

- 3.1 Гэрээт ажлын нийт төлбөр нь татвар хураамж /НӨАТ/ багтсан дүнгээр 13,200,000.00 (арван гурван сая хоёр зуун мянга) төгрөг байна.
- 3.2 Энэ гэрээний нийт төлбөрт Гүйцэтгэгчээс гэрээт ажлыг хийж гүйцэтгэх ажлын хөлс, шаардлагатай материал, ажилтны хөлс, бүх татвар, хураамж болон зардал багтсан болно.
- 3.3 Гэрээний төлбөрийг Захиалагч нь Гүйцэтгэгчид дор дурьдсан хуваарийн дагуу Гүйцэтгэгчийн дансанд нэхэмжлэхийн дагуу шилжүүлнэ. Үүнд:
 - Захиалагч нь энэхүү нэмэлт гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 3 хоногийн дотор гэрээний нийт үнийн дүнгийн 50%-ийн төлбөр болох 6,600,000.00 (зургаан сая зургаан зуун мянга) төгрөгийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн, түүний харилцах дансанд шилжүүлнэ.
 - Тооцоо дуусч гэрээ дүгнэсэн акт баталгаажуулахад бэлэн болсон үед үлдэгдэл төлбөрийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн Худалдаа хөгжлийн банкны 406002860 тоот дансанд ажлын 3 /гурав/ хоногийн дотор шилжүүлнэ.

- 3.4 Гүйцэтгэгч нь Захиалагч гэрээт ажлын төлбөрийг бүрэн төлсөний дараа НӨАТ-ын баримтын бичилт хийнэ.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Захиалагч нь Гүйцэтгэгчийг гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай ТЭЗҮ, Нэгдсэн сүлжээтэй холбогдох схем, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын үндсэн тоноглолын өгөгдөл зэрэг бусад шаардлагатай мэдээллээр бүрэн хангана.
- 4.2 Хийгдэх ажлын хэмжээ өөрчлөгдөх, зогсоох шаардлага гарвал Гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэх, гэрээнд заагдаагүй нэмэлт ажил гарвал Гүйцэтгэгчийн шаардлагыг хүлээн авч шийдвэрлэнэ.
- 4.3 Гүйцэтгэгчээс үл хамаарах нөхцөл байдлын улмаас ажлыг зогсоох, анх өгсөн техникийн өгөгдөл, анхдагч хэлхээний зураг схемд өөрчлөлт орж ажлыг дахин хийх шаардлага гарвал холбогдох зардал, ажлын хөлсийг Гүйцэтгэгчид нэмж төлнө.
- 4.4 Захиалагч нь зураг төслийн болон бусад холбогдох норм дүрэм, стандартыг Гүйцэтгэгч зөрчсөн болон чанарын гологдол гаргасан нь тогтоогдсон тохиолдолд уг доголдлыг арилгахыг шаардах эрхтэй.
- 4.5 Захиалагч нь Гүйцэтгэгчээс гэрээт ажлын гүйцэтгэлийг албан тоот болон гэрээ дүгнэсэн актаар хүлээн авна.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 5.1 Гүйцэтгэгч нь Захиалагчаас шаардагдах өгөгдөл, схем, мэдээллийг болон Захиалагчийн төлбөр төлсөн баримт зэргийг бүрэн хүлээн авсанаар гэрээт ажлыг эхэлнэ.
- 5.2 Гэрээт ажлыг холбогдох норм, дүрэм, стандартын дагуу чанартай гүйцэтгэж гэрээнд заасан хугацаанд багтаан Захиалагчид гэрээт ажлын гүйцэтгэлийг актаар хүлээлгэн өгнө.
- 5.3 Гэрээт ажлын явцад алдаа гарсан нь илэрч зураг төслийн ажлын явцад хүндрэл үүсгэвэл Гүйцэтгэгч өөрийн хүч хөрөнгөөр илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгах үүрэг хүлээнэ.
- 5.4 Гэрээт ажлын гүйцэтгэл, үр дүн нь Захиалагчийн шаардлагад нийцээгүй, чанаргүй гүйцэтгэгдсэн, техникийн нөхцөл, зургийн даалгаврыг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд Захиалагчийн дахин тогтоосон хугацаанд өөрийн хөрөнгөөр мэргэжлийн түвшинд, чанартай гүйцэтгэж гэрээт ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн актаар хүлээлгэн өгнө.
- 5.5 Захиалагчаас шилжүүлэн өгсөн аливаа баримт бичгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцна.
- 5.6 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэхэд Захиалагчаас авсан техникийн үзүүлэлт, тооцоо, баримт материал зэргийг гэрээт ажил дууссаны дараа Захиалагчид хүлээлгэн өгнө.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 6.1 Захиалагч төлбөрийг гэрээнд заасан журмаар төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд үнийн дүнгийн 0.3 %-тай тэнцэх алданги төлнө.
- 6.2 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гэрээний нийт үнийн дүнгийн 0.3 %-тай тэнцэх алдангийг Захиалагчид төлнө.
- 6.3 Талуудын гэрээгээр хүлээсэн үүргээс үүсэх алданги төлөх дээд хэмжээ нь гэрээний нийт үнийн 10 %-аас хэтрэхгүй байна.
- 6.4 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг алдаатай алдаатай гүйцэтгэсний улмаас Захиалагчид хохирол учирсан тохиолдолд Гүйцэтгэгч нь үл маргах журмаар нөхөн төлнө.
- 6.5 Захиалагчийн буруугаас гэрээт ажлын гүйцэтгэл үр дүнгүй болж дахин горимын тооцоо хийх болсон тохиолдолд Захиалагч үл маргах журмаар Гүйцэтгэгчид дахин төлбөр төлнө.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ДҮГНЭХ

- 7.1. Гүйцэтгэгч нь Захиалагчид гэрээт ажлыг албан бичгээр мэдэгдсэнээр энэ гэрээнд заагдсан хугацаанд ажлыг бүрэн гүйцэтгэсэнд тооцно.

7.2. Талууд гэрээт ажлыг гэрээний гүйцэтгэлийг хүлээлцэх актаар баталгаажуулна.

НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

- 8.1. Гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд санал гаргасан Тал нь албан бичгээр нөгөө талдаа саналаа хүргүүлнэ. Хүлээн авсан Тал нь ажлын 5 хоногт хариуг албан бичгээр хүргэнэ.
- 8.2. Нэмэлт, өөрчлөлтийг Талууд харилцан зөвөөрсөн тохиолдолд тус өөрчлөлтийг гэрээнд бичгээр үйлдэж оруулах бөгөөд Талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 8.3. Энэ гэрээний нөхцлүүдийг зөрчсөн буюу гэрээт ажлын гүйцэтгэлтэй холбоотой аливаа зөрчил, маргаантай асуудлыг Талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.
- 8.4. Гэрээнээс үүссэн маргааны зөвшилцөлийг эс зөвшөөрсөн Тал нь Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.5. Энэ гэрээг 2 /хоёр/ эх хувь үйлдэж, баталгаажуулах ба Талууд тус бүр нэг эх хувийг хадгална. Гэрээний эх хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 8.6. Гэрээт ажлыг Талууд бүрэн хүлээлцэж, төлбөр тооцоог 100 хувь барагдуулсанаар гэрээ дуусгавар болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгчийг төлөөлж:
“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК:

Гүйцэтгэх захирал
..... Г.Балжинням

Тэргүүн дэд захирал бөгөөд
Ерөнхий диспетчер
..... Б.Баатар
Зах зээлч санхүү хариуцсан дэд
захирал

..... Ц.Өнөрмаа
СЭЗА-ны дарга
..... Т.Бямбажав


РХАА-ны дарга
..... Ч.Амарсанаа

ЗЭЗА-ны дарга
..... Г.Мөнхбат

Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн
..... Ч.Отгонбаатар

Гэрээний мэргэжилтэн
..... Д.Алимаа

Гүйцэтгэгчийн хаяг:
17032. Улаанбаатар хот
Хан-уул дүүрэг, Чингисийн
Өргөн чөлөө. Засгийн газрын XIV байр
Утас: 70041371
Факс: 70043467
И-мэйл: ndc@ndc.energy.mn



Захиалагчийг төлөөлж:
“Вестерн холд” ХХК
Гүйцэтгэх захирал
..... С.Балжинням

Цахилгааны инженер
..... Д.Зоригт

Захиалагчийн хаяг:
Улаанбаатар хот, Сонгинохайрхан
дүүрэг, 4-р хороо, Хүнсчдийн гудамж,
НПГруппын байр.
Утас: 99153804
Web: westernhold.mn
И-мэйл: westernhold@westernhold.mn